

**Монголчуудын хэл, соёлын онцлог орчин үеийн уран зохиолд илэрсэн нь
(Ардын уран зохиолч Ш.Дулмаагийн “Газар шороондоо би хайртай”
шүлгийн жишээгээр)**

Рагчаагийн БИГЭРМАА*

Монгол Улс, Улаанбаатар хот, Шинжлэх ухаан, Технологийн Их Сургууль,
Гадаад хэлний сургууль

Received: 30 August 2025 / **Accepted:** 15 October 2025 / **Published:** 30 December 2025

Хураангуй: Монгол үндэсний соёл, сэтгэлгээний онцлог нь тэдний эрхэлж ирсэн мал аж ахуй, нүүдлийн соёл иргэнийл, байгаль орчинтой харьцах харьцаа, хандлагатай нягт холбоотой бөгөөд монголчууд дэлхийн хүн төрөлхтний соёл судлал, оюун сэтгэлгээний санд өөрийн гэсэн өвөрмөц соёлыг дархлан үлдээж ирсэн агуу ард түмэн билээ. Монголчуудын соёл, зан заншлын энэ өвөрмөц онцлог тэдний уран зохиолоор дамжин, үр хойчдоо уламжлагдан ирдэг. Энэхүү өгүүлэлдээ бид монголын орчин үеийн уран зохиолд монгол соёл, зан заншлын онцлогийг хэрхэн тусгасан тухай “Ардын уран зохиолч”, яруу найрагч Ш.Дулмаагийн (1934-2024) “Газар шороондоо би хайртай” шүлгийн жишээгээр тайлбарлахыг хичээлээ.

Түлхүүр үгс: Бичгийн уран зохиол, яруу найраг, уламжлал, бэлгэдэл, зан заншил, байгаль хамгаалах, цээрлэх ёс

**The Reflection of Mongolian Linguistic and Cultural Characteristics
in Contemporary Literature
(A Study of the Poem “Gazar shoroondoo bi khairtai” by the Sh. Dulmaa)**

BIGERMAA Ragchaa

School of Foreign Languages, Mongolian University of Science and Technology,
Ulaanbaatar, Mongolia

Abstract: The distinctive features of Mongolian national culture and mentality are closely intertwined with their traditional pastoral economy, nomadic civilization, and harmonious relationship with nature. Mongolians are a great people who have preserved and contributed a unique cultural identity to the global treasury of human civilization and intellectual heritage. This distinctive

* © Р.Бигэрмаа, 2025, Email: bigermaa@must.edu.mn, <https://orcid.org/0000-0003-2033-5441>



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license.

cultural and traditional character of the Mongols has been transmitted to future generations through their literature and artistic expression. In this paper, we aim to explain how the language and culture of Mongolians are reflected in modern literature, especially in poetry, with the example of the poem "Gazar shoroondoo bi khairtai" by Sh. Dulmaa (1934-2024).

Key words: *Written Literature, Poetry, Tradition, Symbolism, Customs, Environmental Protection, and Taboos*

1. Удиртгал

Монголын орчин үеийн уран зохиол 1920-оод оноос хойш монголчуудын нийгэм, түүхийн хөгжил дэвшлийг тусган, улам боловсронгуй болж хөгжсөөр иржээ. Уран зохиолоор дамжуулан тухайн улс үндэстэн өөрсдийн соёл, урлагийн гайхамшигт бүтээлийг туурвиж, бусад улс үндэстний уран зохиолоос тэдний соёл, уламжлалыг танин мэдэхээс гадна өөрийн соёлыг үр хойчдоо уламжлан дамжуулж байдаг. Өөрөөр хэлбэл, уран зохиол нь тухайн улс үндэстний хэл, соёл, түүхийн өвийг тээдэг. XXI зуун даяаршил, олон үндэстний соёлын солилцооны зуун учраас аливаа улс үндэстэн өөрийн өв соёл буюу ондоошлыг хайрлан хамгаалж, хөгжүүлэх хэрэгтэй болж байна. Иймд бид монгол соёл, сэтгэлгээний онцлог уран зохиолд хэрхэн илэрч буйг судлах, гадаад дотоодын судлаачдын анхаарлыг татах, үр хойчдоо өвлүүлэн үлдээх, цахим орчныг ашиглан тайлбарлан таниулах зэрэг чухал асуудлыг хөндөх зорилготой.

Бид энэхүү өгүүлэлдээ монголчуудын хэл, соёлын онцлогийг орчин үеийн уран зохиолд, ялангуяа яруу найрагт хэрхэн туссаныг Ардын уран зохиолч Ш.Дулмаагийн “Газар шороондоо би хайртай” шүлгээр жишээлэн тайлбарлахыг зорилоо. Тус шүлэгт дүрслэгдэж буй монголчуудын нүүдлийн соёл иргэншлийн онцлог, монгол хүний амьдрах амьдралын мөчлөг, хүн ба байгалийн холбоо хамаарал зэргийг ажигласны үндсэн дээр монголчуудын уламжлалт сэтгэлгээг таниулах, уламжлан хөгжүүлэх, амьдралд хэрэглэх асуудлыг хөндөж, хойч үедээ тайлбарлан таниулах, мэдээллийн эрин зуунтай холбох санаа нь энэхүү өгүүллийн зорилго, үнэ цэн, шинэлэг тал болох юм.

2. Судалгааны арга зүй

Судалгааны ажлын зорилгод хүрэхийн тулд бид онол, практикийн судалгааг хийсэн бөгөөд задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, ажиглах зэрэг аргыг хэрэглэсэн болно.

Эрт дээр үеэс эрдэмтэн судлаачид аливаа улс үндэстний хэл, сэтгэлгээ, соёл, ахуйн холбоо хамаарлыг судалж, тэдгээр нь хоорондоо харилцан нягт уялдаа холбоотой, нэг нь нөгөөгөө нөхцөлдүүлэн холбож ирсэн зүй тогтлыг тайлан тайлбарласаар иржээ. “Соёл” нь өргөн цар хүрээтэй, агуулга хэлбэрийн хувьд үлэмж баян, нийгмийн үзэгдэл юм. Энэ нь өөрөө, бүхэллэг шинжтэй нийгмийн үзэгдэл учраас түүнийг эртний судлал, угсаатны зүй, хүн судлал, хэл шинжлэл, урлаг судлал, сэтгэл зүй, сурган хүмүүжүүлэх ухаан, нийгэм түүх, философи зэрэг нийгэм хүмүүнлэгийн олон шинжлэх ухаанд судалгааны хэрэглэгдэхүүн болгон судалсаар байна. Соёл нь тухайн улс үндэстний түүх, уламжлалтай нягт холбоотой бөгөөд тэрхүү үндэстний зан заншил, амьдрах орчин нөхцөл, ахуй соёл, аж төрөх ёсон, сүшиг бишрэл, амьдралын хэв маяг, өөрийгөө үнэлэх үнэлэмж, сэтгэлгээний онцлог зэргийг багтаасан ойлголт юм.

3. Хэл, соёлын онцлог ба илрэл

Монгол үндэсний соёл, сэтгэлгээний онцлог нь тэдний эрхэлж ирсэн мал аж ахуй, нүүдлийн соёл иргэншил, байгаль орчинтой харьцах харьцаа, хандлагатай нягт холбоотой бөгөөд монголчууд дэлхийн хүн төрөлхтний соёл судлал, оюун сэтгэлгээний санд өөрийн гэсэн өвөрмөц соёлыг дархлан үлдээж ирсэн агуу ард түмэн билээ. Монголчуудын соёл, зан заншлын энэ өвөрмөц онцлог тэдний уран зохиолоор дамжин, үр хойчдоо уламжлагдан ирдэг. Орчин

үеийн яруу найрагт монголчуудын нүүдлийн соёл иргэншилтэй холбоотойгоор тэдний оюун сэтгэлгээний салшгүй нэг хэсэг болж ирсэн, байгаль дэлхийгээ хайрлах хамгаалах үзэл санаа, эх орныхоо сайхныг бахархах мөнхийн үнэт зүйлсийг зохиолч бүр өөр, өөрийн өвөрмөц өнгө төрхтэйгөөр тусган харуулж ирснийг бид мэднэ. Ингээд Ардын уран зохиолч Ш.Дулмаагийн “Газар шороондоо би хайртай” шүлгийг ажиглая.

Тус шүлэг нийтдээ 8 бадаг, 40 шад шүлэг бөгөөд монгол шүлгийн бүтцийн үндсэн онцлог болох 4 шадаар бадаглаж, 5 дахь шадыг “Газар шороондоо би хайртай” гэсэн давталтаар утга санааг тодотгосон, монголчуудын мөнхийн үнэт зүйл болох эх орноо хайрлах, бахархах сэтгэлгээг илэрхийлсэн шүлэг ажээ. Ингэж эх орныхоо сайн сайхнаар бахархан дүрслэх дүрслэл монголын яруу найрагт эртний уламжлалтай юм. Тухайлбал, бид орчин үеийн уран зохиолын төлөөлөгчдөөс нэрт яруу найрагч Д.Нацагдоржийн “Миний нутаг”, Б.Явуухулангийн “Би хаана төрөө вэ?”, Б.Лхагвасүрэнгийн “Боржигоны бор тал” гэх мэт олон шүлгийг мэднэ.

Энэхүү найрагчдын шүлгийг ажиглахад, эх орны тухай өгүүлэмжийг өөрсдийн урлах ур чадвар, амьдралын туршлага, билгийн хараа, сэтгэлгээний онцлогоос шалтгаалан, өөр өөр өнцгөөс өвөрмөцөөр өгүүлдэгтэй адил, Ш.Дулмаа найрагч ч бас өөрийн онцлогтойгоор дүрсэлжээ. Үүнд:

1. Найрагч шүлгийн гол санааг илэрхийлэхдээ байгаль, хүн хоёрын хүйн холбоог “Би” баатрын өсөж төрсөн цагаас хөлд орох бага нас, өсвөр нас, идэр нас гэх мэтээр хүний амьдралын нэгэн мөчлөгөөр дүрслэн харуулахдаа нийгмийн хөгжлийн онцлог үеүдтэй холбон харуулсан.
2. Монголчууд нүүдлийн соёл иргэншилтэй ард түмэн бөгөөд эрхэлж буй мал аж ахуй, амьдралын хэв маяг, зан заншил нь байгаль орчинтойгоо нягт уялдаа холбоотой. Өөрөөр хэлбэл, байгалийн эрс тус уур амьсгалтай, жилийн дөрвөн улиралд нүүдэллэн амьдардаг амьдралын өдөр тутмын зан заншил, дадал хэвшил нь байгалиа хайрлах хамгаалах, унаган төрхөөр нь хадгалахад чиглэдэг байжээ. Тухайлбал, хүүхэд багачуудыг хэлд ормогц сайн үйлийг “Арван цагаан буян”, аливаа буруу үйлийг “Арван хар нүгэл” хэмээн сургаж, тэднийг хөлд ормогц байгаль орчинтойгоо зөв харьцуулах анхны цагаан толгойг “Ус бохирдуулж болохгүй.”,”Ургамал ногоо тасдаж болохгүй.”,”Түүхдээ үндсээр нь тасалж болохгүй-нүгэл” хэмээн сургадаг байсан нь угтаа байгалиа хамгаалах арга байжээ. Энэ нь монголчуудын цээрлэх ёсоор тайлбарлагдана. Өөрөөр хэлбэл, монголчуудын сэтгэлгээний нэг онцлог болсон цээрлэх ёсны ачаар бид унаган байгалиа өдий хүртэл хадгалж ирсэн уламжлалтай, байгальтайгаа хүйн холбоотой ард түмэн билээ.
3. Тэрчлэн дэлхий нийтээр даяаршиж буй өнөөгийн нийгэмд монголчуудын бусад улс үндэстнээс ялгарах соёлын ондоошлыг нүүдэлчдийн хэл соёлын онцлог бүхий үг хэллэгээр дүрсэлжээ. Жишээлбэл: “Хөлд орохдоо унаж босон мөрөө гаргаж” (Дулмаа, 1966:75) гэсэн хэллэгээр бага наснаасаа эхлэн, байгальтайгаа хүйн холбоотой байж, тэнцэж ядан алхаж сурахдаа өөрийн гэсэн орон зайтай хүн гэдгээ илэрхийлж, нөгөө талаас монголчууд эрт дээр үеэс хүүхдээ хөлд ормогц нь эхлээд арьсан бойтогтой ойр зуур явуулж, дараа нь хөл нүцгэн алхуулдаг. Хонь хариулах, аргал түүх, ус зөөхөд ч хөл нүцгэн явуулдаг байсан онцлогийг тусгажээ. Тэд эх байгалийнхаа хөрс уснаас хөлөөрөө "шим", "эрчим хүч" авч арван хэдэн нас хүртлээ байгаль эхтэйгээ шууд холбоотой өсдөг учир чийрэг бөгөөд эрүүл хүн болно гэж үздэг байв. “Хүйтэн булгийн уснаас шүдээ таштал залгилж”, “Толгодын энгэрээр хургаа хариулж” (Дулмаа, 1966:75) гэсэн үг хэллэгээр монголчууд үр хүүхдээ бага балчир наснаас, өөрөөр хэлбэл, хөлд орохоос нь эхлэн гаднаас 1-2 ширхэг аргал оруулах, аяга шаазан дөхүүлэх, улмаар 4-5 насанд хүрэхээр нь гэр ахуй, мал аж ахуйн ажилд сургах, тухайлбал, таван хошуу малд хайртай, хөдөлмөрч болгон мал сүргийн ашиг шимийг дээдлэн сургахын хамт нутаг усныхаа ахмад хүмүүсийг хүндлэх хэв ёсноос зааж, гэр бүлийн хүмүүжлийг олгодог заншилтай байжээ. “Тоодон дээлэндээ чулуу хормойлж гэр барин” (Дулмаа, 1966:75) хэллэгээр монгол хүүхдийн тоглох онцлогийг харуулжээ.

Монголчууд байгаль орчин, мал аж ахуйтай холбоотойгоор үндэсний онцлог хувцас болох дээлийг бага насны хүүхдэд тоодгор жижиг, богинохон хийж өмсүүлдэг, хүүхдүүд тэрхүү дээлийнхээ хормойд чулуу түүж, зөөн гэр барьж тоглодог уламжлалтай. Дээл нь монгол үндэсний хувцас бөгөөд олон зуун жилийг дамжсан баялаг түүхтэй билээ. Энэ

хувцас нь монголчуудын амьдралын хэв маягийг харуулдаг. Үндэсний хувцас нь тухайн хүрээлэн буй орчин, талаар морь унан давхих, гэрт байхад эсвэл баяр наадамд бүжиглэхээс хамааран өөр, өөр байдаг. Зуны улиралд монголчууд тэрлэг, хавар, намрын улиралд хөвөнтэй эсвэл хурган дээл, өвлийн улиралд хонины арьсаар хийсэн цагаан нэхий дээл өмсдөг.

Монгол хүүхдүүд тоглохдоо хонь ямаагаа хариулдаг шилбүүрээ унаад морь унаж тоглох, хонины бэлчээр болон голын эрэг дээр чулуугаар гэр барин өрж тоглох, жижиг чулуугаар таалцан тоглох гэх мэтээр хээрийн нөхцөлд юмханаар юмхан хийж тоглодог ажээ. “Унасан морины туурай газар хонхойтол цавчилж” (Дулмаа, 1966:75) гэсэн дүрслэлээр монголчууд морийг дээдлэн хүндэлж, алтан соёмбот төрийнхөө бэлгэдэлд хүртэл дүрсэлдэг, “Эр хүний сайн нөхөр” хэмээн үздэг уламжлалыг тусган харуулжээ. “Харийн дайсан халдахад гал голомтоо хамгаалж” (Дулмаа, 1966:75) гэсэн дүрслэлээр “Эх орон”-оо хайрлан хамгаалах үзэл санааг монголчуудын “Гал голомт” хэмээх шүтлэг, бэлгэдлээр илэрхийлэхдээ Тэнгэр бол мөнхийн бэлгэдэл, гал-ариуны бэлгэдэл билээ. “Гал голомт бол аугаа их хүчийг өгдөг төв, гэрийн амин сүнс. Түүнийг хүндэтгэвэл айл гэрийн хамаг бүхэн өөдлөн дэвжиж, гэр бүлийн гишүүн бүрд илч эрчим харамгүй түгээгдэнэ. Эр хүн галгүй явахыг цээрлэж, хэт цахиураа анд нөхөр мэт үзнэ. Түлээ модгүй болж гал алдахыг ихэд жигшинэ. Иймээс гал голомтоо маш сайн хамгаалах хэрэгтэй.” гэсэн монголчуудын үзлийг дүрсэлжээ.

4. Нийгэм соёлын антропологийн нэг чиглэл болох “Хүний экологи” (Human ecology)-ийн талаарх сэдвийг хөнджээ. Энэ нь хүн судлал дахь “Хүн-байгаль” хоёрын хоорондын харилцааны судалгаа (Эрдэнэтуяа, 2007:9) юм. Энэхүү салбар нь нэг талаас хүн байгальтайгаа хэрхэн зохицож буйг, нөгөө талаас байгаль орчноос хүний нийгэмд үзүүлж буй нөлөөг судалдаг. Найрагч энэхүү шүлэгтээ энэ сэдвийг тусгахдаа хүн, байгальтайгаа хэрхэн зохицож буйг монгол хүүхдийн байгаль орчинтойгоо харьцах харьцаагаар, тухайлбал, төрсөн цагаасаа эхлэн, булгийн усаа ууж, таанын толгой цэцгийн дэлбээ түүх, чулуу хормойлж тоглох, алтан шар замаа ширтэх, эх орноо хамгаалахдаа чулуугаа боож авч явж буй, атар газартаа тариа тариалж буй, арвин талынхаа уудамд цуурай хадтал дуулж өсөж буй зэрэг дүрслэлээр илэрхийлсэн байна.
5. “Газар шороондоо би хайртай” шүлэг нь (Дулмаа, 1966:75) зохиомжийн хувьд өвөрмөц. “...Зохиолд бүрэлдэж буй зан төрх, хэв шинж, уран дүрийн бүтэц, дүрслэх аргын бүтэц байгуулалтын тогтолцоог бүхэлд нь зохиомж (Галбаатар, 2012:183)” гэнэ. Гол дүрийн “Би” баатрын сэтгэлийн өчиг, сэтгэл зүйн өсөлт, өөрчлөлтийг харуулахдаа хөлд орж буй бага насны дүр зургаас өтөл нас хүртэлх дүрийн өсөлт болон байгалийн зураглал, бодол эргэцүүлэмжийг дурсаж дурсамж (Галбаатар, 2012:134) хэлбэрээр бичсэнээрээ онцлог.
6. Мөн монгол шүлгийн 4 шадаар бадаглах зарчмыг шинэчилж, 5 шадаар бичихдээ тав дахь бадгийг давталтаар илэрхийлсэн. “Газар шороондоо би хайртай” гэсэн энэхүү давталт нь нэг талаас зохиолчийн үзэл санаа, сэтгэлгээний цар хүрээг илэрхийлэхийн зэрэгцээ монголчуудын “Газар бол амьдралын үндэс, эх орныхоо эд эс бүрийг хамгаалах ёстой.” гэсэн нийтлэг үзлийг тусган, “Газар шороо” гэсэн хэвшмэл хэллэгийг сонгон хэрэглэсэн нь шүлгийн далд утга санааг илэрхийлэхэд ач холбогдолтой болжээ.

4. Дүгнэлт

Дээрх баримтуудаас дүгнэхэд:

1. “Газар шороондоо би хайртай” шүлэг нь монгол хүний төрсөн цагаас өтлөх хүртэлх амьдралын мөчлөгийг дүрслэн харуулахдаа соёл, зан заншлын бусад улс үндэстнээс ялгарах ондоошлыг дүрслэн харуулжээ.
2. Ингэж дүрслэхдээ зөвхөн нүүдлийн соёл иргэншилт улс орны амьдралын хэв маяг, онцлогийг тусгасан нүүдэлчдийн хэл, соёлыг илэрхийлсэн нь шүлгийн зохиомж, дүрслэлээс тодорхой байна.
3. Монгол хүн өсөхөөс өтлөх хүртэл байгаль дэлхийтэйгээ хүйн холбоотой байж, байгальдаа уусан шингэдгийг харуулснаараа өвөрмөц содон шүлэг болжээ.

4. Уран зохиолд монголчуудын хэл, соёлын онцлог, ондоошил хэрхэн илэрч байгааг судалж, дэлхий нийтэд түгээн дэлгэрүүлэх арга замыг эрэлхийлэх нь бидний судалгаанд чухал ач тустай.

Ном зүй

- Бигэрмаа, Р.** (2016). *XX зууны яруу найргийн шинэтгэл шинж*. Улаанбаатар. [Bigermaa, R. *XX zuunii mongol yaruu nairgiin shinetgel shinj*. [The Literary Movements in the Twentieth Century Prose Poetry Mongolian. Ulaanbaatar:2016]
- Галбаатар, Д.** (2012). *Уран зохиолын нэр томъёоны нэвтэрхий толь: Онол, түүх, шүүмжлэл*. Улаанбаатар:Соёмбо хэвлэх үйлдвэр. [Galbaatar D *Uran zokhiolyn nevterkhii toli:Onol, tuukh, Shuumjlel*. [Encyclopedia of Literature: Theory, History and Critism.] Ulaanbaatar. Soyombo Print LLC., 2012]
- Дулмаа, Ш.** (1989). *“Галын тэнгэр” Бүрэн түүвэр*. Улаанбаатар:Улсын хэвлэлийн газар. [Dulmaa, Sh. *Galiin tenger. Buren tuiiver*. [The sky of flame] Ulaanbaatar:Ulsyn khvleliin gazar.1989]
- Уэллек, Р., Уоррен, О.** (2015). *Уран зохиолын онол*. Улаанбаатар: МУИС хэвлэх үйлдвэр. [Wellek, R., & Warren, O. *Uran zokhiolyn onol*. [Theory of Literature. Ulaanbaatar: National University of Mongolia Press. 2015]
- Эрдэнэтуяа, У.** (2003). *“Байгаль-нийгмийн хосолмол судалгааны өнөөгийн чиг хандлагын тойм”*. Улаанбаатар. [Erdenetuya, U. *Baigali niigmiin khosolson sudalgaany onöögiiin chig khandlagyn toim*. [An Overview of Current Trends in Coupled Human–Natural Systems (Socio-Ecological) Research] Ulaanbaatar. 2003]